



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 30 өдөр

Дугаар

А/650

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг гүйцэтгэгч “Тома-Алтай” ХХК-ний ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ш.Батсүх - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нутгийн удирдлага, бодлого зохицуулалтын хэлтсийн дарга

Гишүүд:

Л.Батгэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Сонинтуяа - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

О.Очирбат - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын олон нийттэй харилцах хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Б.Даваадорж - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нутгийн удирдлага, бодлого зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн, нягтлан бодогч

2. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг гүйцэтгэгч “Тома-Алтай” ХХК-ний ажлыг хүлээн авах ажлыг захиалагчаас баталсан ажлын даалгаврын дагуу шалгаж хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Ш.Батсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ